



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/239/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn  
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ  
Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг  
Утас: 99016320 Цахим хаяг: erdeneega@audit.gov.mn  
Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн  
Ерөнхий захирал: Т.Батсайхан  
Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com  
Аудитын менежер: Г.Оюунгэрэл  
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com  
Аудитор: Г.Мөнхбаяр  
Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	14
3.6.3 Нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
3.9.3 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт .....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/178  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГА Г.ОЮУНЖАРГАЛ  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,172,680,702.49</b>	<b>3,511,215,956.83</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	17,632,077.56
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	17,632,077.56
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	17,632,077.56
31211	Төрийн сангийн харилцах	00.00	4,824,367.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	12,807,710.56
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	25,984,770.00	2,264,249,956.57
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	2,260,812,478.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	25,984,770.00	3,437,478.57
3351	Байгууллагаас авах авлага	25,984,770.00	3,437,478.57
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,146,695,932.49	1,229,333,922.70
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	725,580,037.65	830,964,704.91
35110	Тусгай зориулалттай материал	238,665,016.53	174,173,119.69
35130	Эм боох материал	486,915,021.12	656,791,585.22
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	421,115,894.84	398,369,217.79
35410	Бичиг хэргийн материал	1,258,635.00	323,690.00
35420	Аж ахуйн материал	63,878,286.00	70,429,086.00
35430	Сэлбэг хэрэгсэл	67,500.00	582,500.00
35440	Түлш, шатах тослох материал	5,074,840.00	240,000.00
35450	Барилгын засварын материал	20,786,820.00	1,933,900.00
35460	Хүнсний материал	42,761,402.20	12,643,785.00
35470	Бусад хангамжийн материал	287,288,411.64	312,216,256.79
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,397,524,150.06</b>	<b>15,550,085,937.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	13,397,524,150.06	15,550,085,937.91
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	12,277,839,775.06	14,428,449,687.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,243,113,395.41	9,079,907,109.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-990,819,979.87	-1,195,426,731.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	625,759,379.00	350,218,195.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-439,603,901.37	-137,688,392.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,959,421,089.62	9,794,473,465.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,431,303,760.64	-3,747,521,555.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	413,932,683.07	363,005,381.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-225,040,875.70	-184,380,725.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	154,208,413.40	154,208,413.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-31,826,667.86	-48,345,471.82
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,119,684,375.00	1,121,636,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,331,646,435.60	1,121,782,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-211,962,060.60	-146,250.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>14,570,204,852.55</b>	<b>19,061,301,894.74</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>25,984,770.00</b>	<b>1,005,260,568.01</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	25,984,770.00	1,005,260,568.01
<b>413</b>	<b>Өглөг</b>	25,984,770.00	1,005,260,568.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	914,182,568.01
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	25,984,770.00	91,078,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	25,984,770.00	91,078,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,544,220,082.55</b>	<b>18,056,041,326.73</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	14,544,220,082.55	18,056,041,326.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,126,931,228.10	7,126,931,228.10
51101	Өмч: - төрийн	7,126,931,228.10	7,126,931,228.10
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,607,253,444.19	6,508,778,248.71
51210	Өмнөх үеийн үр дүн	2,607,253,444.19	2,996,957,004.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,511,821,244.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,810,035,410.26	4,420,331,849.92

6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> <b>VI=IV+V</b>	<b>14,570,204,852.55</b>	<b>19,061,301,894.74</b>
---	--	--------------------------	--------------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>13,094,727,853.54</b>	<b>19,153,638,286.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,445,546,098.54</b>	<b>5,164,939,685.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,445,546,098.54	5,164,939,685.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	259,451,182.00	327,126,424.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	259,451,182.00	327,126,424.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө	00.00	3,549,552,084.55
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	00.00	1,288,261,177.35
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,649,181,755.00</b>	<b>13,988,698,600.40</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,236,035,400.00	890,655,760.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,236,035,400.00	890,655,760.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	138,036,240.00	718,652,169.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,400,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,250,000.00	10,608,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	539,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	129,786,240.00	46,203,969.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нэмэлт орлого	00.00	114,040,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,275,110,115.00	12,379,390,671.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,275,110,115.00	12,379,390,671.40
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>11,741,172,875.46</b>	<b>15,656,431,408.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>11,741,172,875.46</b>	<b>15,656,431,408.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	11,661,171,624.57	15,077,065,258.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,857,035,426.18	6,292,996,772.00
210101	Үндсэн цалин	4,657,626,033.32	3,468,256,205.00
210102	Нэмэгдэл	955,953,992.87	2,053,872,949.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,393,800.00	286,565,640.00
210104	Урамшуулал	119,061,599.99	484,301,978.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	744,905,833.00	824,253,405.87
210201	Тэтгэврийн даатгал	511,327,533.00	579,014,030.25
210202	Тэтгэмжийн даатгал	58,394,600.00	61,762,569.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,715,600.00	49,409,975.58
210204	Ажилгүйдлийн даатгал	11,678,900.00	12,188,020.93
210205	Эрүүл мэндийн даатгал	116,789,200.00	121,878,809.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,210,599,610.93	1,363,171,804.43
210301	Гэрэл, цахилгаан	114,993,827.93	121,843,952.87
210302	Түлш, халаалт	788,168,183.00	802,230,220.86
210303	Цэвэр, бохир ус	307,437,600.00	439,097,630.70

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	184,613,907.85	313,934,082.79
210401	Бичиг хэрэг	7,505,090.00	6,858,100.00
210402	Тээвэр, шатахуун	55,900,204.00	63,652,382.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,010,508.06	11,590,783.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,277,820.00	2,460,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,725,851.00	57,604,434.00
210408	Бараа материал акталсны зардал	55,194,434.79	171,768,182.99
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,101,987,831.77	4,450,337,978.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,911,633,860.97	4,207,525,520.13
210502	Хоол, хүнс	189,303,570.80	236,729,308.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,050,400.00	6,083,150.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	161,211,759.00	70,823,535.92
210604	Урсгал засвар	161,211,759.00	70,823,535.92
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,824,800.00	7,672,000.00
210702	Дотоод албан томилолт	6,824,800.00	7,672,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,987,537.50	178,146,866.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,685,402.50	148,604,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900,000.00	1,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,467,900.00	6,120,096.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	482,510.00	422,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	352,000.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	350,000.00
210807	Газрын төлбөр	3,270,800.00	2,921,625.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,828,925.00	17,498,345.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,356,004,918.34	1,575,728,812.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,134,600.00	29,540,870.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,338,870,318.34	1,546,187,942.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	80,001,250.89	579,366,150.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	48,342,821.00	579,366,150.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	579,366,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,342,821.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	31,658,429.89	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,353,554,978.08</b>	<b>3,497,206,877.98</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	16,539,220.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	00.00	16,539,220.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	1,924,853.80
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,924,853.80
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	14,614,366.20
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,353,554,978.08</b>	<b>3,511,821,244.18</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,810,035,410.26	2,607,253,444.19	14,544,220,082.55

D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,810,035,410.26	2,607,253,444.19	14,544,220,082.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	389,703,560.34	389,703,560.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,126,931,228.10	4,810,035,410.26	2,996,957,004.53	14,933,923,642.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-389,703,560.34	00.00	-389,703,560.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,511,821,244.18	3,511,821,244.18
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,126,931,228.10	4,420,331,849.92	6,508,778,248.71	18,056,041,326.73

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>10,910,207,037.00</b>	<b>12,055,012,546.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>261,025,282.00</b>	<b>327,126,424.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	261,025,282.00	327,126,424.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	261,025,282.00	327,126,424.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	261,025,282.00	327,126,424.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,649,181,755.00</b>	<b>11,727,886,122.40</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,236,035,400.00	890,655,760.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,236,035,400.00	890,655,760.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	138,036,240.00	672,626,169.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,400,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,250,000.00	10,608,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	539,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	129,786,240.00	46,203,969.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нэмэлт орлого	00.00	68,014,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,275,110,115.00	10,164,604,193.40
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,275,110,115.00	10,164,604,193.40
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>10,565,377,637.00</b>	<b>11,886,257,968.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>10,565,377,637.00</b>	<b>11,886,257,968.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>10,485,376,386.11</b>	<b>11,306,891,818.76</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,850,803,826.18	6,286,236,872.00
210101	Үндсэн цалин	3,202,962,390.00	3,461,496,305.00
210102	Нэмэгдэл	1,924,894,122.79	2,053,572,949.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	248,572,358.40	286,565,640.00
210104	Урамшуулал	474,374,954.99	484,601,978.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	744,905,833.00	827,690,884.44
210201	Тэтгэврийн даатгал	511,327,533.00	582,451,508.82
210202	Тэтгэмжийн даатгал	58,394,600.00	61,762,569.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,715,600.00	49,409,975.58
210204	Ажилгүйдлийн даатгал	11,678,900.00	12,188,020.93
210205	Эрүүл мэндийн даатгал	116,789,200.00	121,878,809.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,210,599,610.93	1,260,828,943.23
210301	Гэрэл, цахилгаан	114,993,827.93	121,843,952.87
210302	Түлш, халаалт	788,168,183.00	699,887,359.66
210303	Цэвэр, бохир ус	307,437,600.00	439,097,630.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	159,013,256.06	150,769,595.80
210401	Бичиг хэрэг	7,050,000.00	7,384,300.00
210402	Тээвэр, шатахуун	60,148,740.00	57,817,522.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,010,508.06	11,590,783.00
210404	Ном, хэвлэл	1,779,110.00	15,400,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,427,820.00	2,468,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,597,078.00	56,108,990.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,265,332,289.94	2,610,110,029.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,019,133,188.94	2,354,858,136.37
210502	Хоол, хүнс	200,598,800.00	212,103,909.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,600,301.00	43,147,984.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	193,154,660.00	64,953,122.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,226,000.00	00.00
210602	Тавилга	4,433,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,496,900.00	7,343,124.92
210604	Урсгал засвар	172,998,760.00	57,609,998.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,824,800.00	7,672,000.00
210702	Дотоод албан томилолт	6,824,800.00	7,672,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	37,607,510.00	85,730,721.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,685,400.00	57,604,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900,000.00	1,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,467,900.00	6,120,096.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	482,510.00	422,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	352,000.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	350,000.00
210807	Газрын төлбөр	3,270,800.00	2,921,625.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,448,900.00	16,082,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,134,600.00	12,899,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,134,600.00	12,899,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,001,250.89</b>	<b>579,366,150.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	48,342,821.00	579,366,150.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	577,866,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48,342,821.00	1,500,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	31,658,429.89	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>344,829,400.00</b>	<b>168,754,577.64</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>344,829,400.00</b>	<b>151,122,500.08</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>344,829,400.00</b>	<b>151,122,500.08</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	344,829,400.00	151,122,500.08
220001	Барилга байгууламж	00.00	47,166,810.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	344,829,400.00	103,955,690.08

6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-344,829,400.00</u></b>	<b><u>-151,122,500.08</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	17,632,077.56
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	17,632,077.56

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	13,320,414,300.00	11,377,562,010.40
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	13,320,414,300.00	11,377,562,010.40
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	13,280,648,100.00	11,337,795,860.40
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	6,656,226,000.00	6,258,225,932.00
210101	Үндсэн цалин	3,374,204,400.00	3,458,180,549.00
210102	Нэмэгдэл	2,509,778,900.00	2,028,877,765.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	266,112,000.00	286,565,640.00
210104	Урамшуулал	506,130,700.00	484,601,978.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	876,257,000.00	822,184,269.00
210201	Тэтгэврийн даатгал	636,821,000.00	576,944,893.38
210202	Тэтгэмжийн даатгал	59,859,000.00	61,762,569.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,887,200.00	49,409,975.58
210204	Ажилгүйдлийн даатгал	11,971,800.00	12,188,020.93
210205	Эрүүл мэндийн даатгал	119,718,000.00	121,878,809.72
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,363,172,000.00	1,260,828,943.23
210301	Гэрэл, цахилгаан	121,844,000.00	121,843,952.87
210302	Түлш, халаалт	802,230,300.00	699,887,359.66
210303	Цэвэр, бохир ус	439,097,700.00	439,097,630.70
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	155,239,200.00	134,432,764.80
210401	Бичиг хэрэг	6,980,000.00	6,924,217.00
210402	Тээвэр, шатахуун	60,148,800.00	57,340,774.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,596,900.00	11,590,783.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,566,000.00	2,468,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,947,500.00	56,108,990.00
2105	<b>Нормативт зардал</b>	3,799,335,300.00	2,603,620,967.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,538,240,100.00	2,348,369,074.37
210502	Хоол, хүнс	215,494,800.00	212,103,909.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,600,400.00	43,147,984.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	334,628,300.00	163,300,613.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	126,500,000.00	65,383,190.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	55,496,900.00	45,915,625.00
210604	Урсгал засвар	152,631,400.00	52,001,798.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	13,810,800.00	7,672,000.00
210702	Дотоод албан томилолт	13,810,800.00	7,672,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	61,979,500.00	77,630,721.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,891,500.00	49,504,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900,000.00	1,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	6,159,400.00	6,120,096.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	494,800.00	422,500.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	363,000.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	659,200.00	350,000.00
210807	Газрын төлбөр	3,062,700.00	2,921,625.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,448,900.00	16,082,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20000000.00</b>	<b>9899650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	9,899,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39766200.00</b>	<b>39766150.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,766,200.00</b>	<b>39,766,150.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,766,200.00	39,766,150.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,320,414,300.00</b>	<b>11,382,386,377.40</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>890,655,760.00</b>	<b>890,655,760.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	890,655,760.00	890,655,760.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>12,109,743,740.00</b>	<b>10,164,604,193.40</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,109,743,740.00	10,164,604,193.40
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>320,014,800.00</b>	<b>327,126,424.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	320,014,800.00	327,126,424.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>4,824,367.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>384.00</b>	<b>384.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	334.00	334.00
620003	Үйлчлэх ажилтан	49.00	49.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>384.00</b>	<b>384.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	322.00	322.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	62.00	62.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>659,818,458.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>612651648.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>73,051,648.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>28,010,940.00</b>
210101	Үндсэн цалин	3,315,756.00
210102	Нэмэгдэл	24,695,184.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,506,615.44</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,506,615.44
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,336,831.00</b>
210401	Бичиг хэрэг	460,083.00
210402	Тээвэр, шатахуун	476,748.00
210404	Ном, хэвлэл	15,400,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,489,062.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,489,062.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,608,200.00</b>
210604	Урсгал засвар	5,608,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,100,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,100,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	539600000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	539,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	538,100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>47,166,810.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	47,166,810.00
220001	Барилга байгууламж	47,166,810.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	672,626,169.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	672,626,169.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,400,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,608,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	539,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,203,899.00
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нэмэлт орлого	68,014,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	12,807,710.56
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,807,710.56

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн нийгмийн даатгалын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг баримт болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийн тусгасан болно.

Аудитыг чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт,

амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/A/268 дугаар тушаалаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журам баталсан байна.
- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 11,741.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 176.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 140.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.5 сая төгрөгөөр буюу 30.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	17.6	17.6
Авлага	25.9	2,264.2	2,238.3
Бараа материал	1,146.7	1,229.3	82.6
Биет хөрөнгө	12,277.8	14,428.4	2,150.6
Биет бус хөрөнгө	1,331.6	1,128.8	209.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>14,570.2</b>	<b>19,061.3</b>	<b>4,491.1</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>14,570.2</b>	<b>19,061.3</b>	<b>4,491.1</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 17.6 сая төгрөг байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсон тул нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 13.5 хувь байснаас 12.5 хувь болж буурсан зөрүүний хэмнэлт байна.

Авлагын үлдэгдэл 2,238.2 сая төгрөг байгаа нь НДС-аас авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 3.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас авах 2,260.8 сая төгрөгийн авлагатай байна. Авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 82.6 сая төгрөгөөр өссөн нь эрүүл мэндийн газраас ковидын вакцин 14.4 сая төгрөгөөр, эм боох материал 169.9 сая төгрөгөөр өсөж, хангамжийн материал 22.7 түлш шатах тослох материал 4.8 сая төгрөгөөр, хүнсний материал 30.1 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Биет хөрөнгийн үлдэгдэл 2,150.6 сая төгрөгөөр өссөн нь 2,150.6 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, Видео ларингоскоп 3.5 сая, амьсгалын аппарат 34.0 сая, хүчил төрөгч өтгөрүүлэгч 3.3 сая төгрөгийн хандив тус тус авсантай, аймгийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, Эхо аппарат, дуслын памп, тарианы шахуурга, хүчил төрөгч өтгөрүүлэгч, хяналтын монитор гэх мэт тоног төхөөрөмж хүлээн авсан байна. Дээд шатны төсөв захирагчаас 43,221.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж авсан, Улсын төсвөөр 857.9 сая төгрөгийн хүчил төрөгчийн тоног төхөөрөмж, чих хамар хоолойн ком багаж, цогцос хадгалах хөргөгч гэх мэт тоног төхөөрөмж 142.3 сая, төсөл хөтөлбөрөөр нийтдээ 1,447.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг авч бүртгэлд тусгасан.

Биет бус хөрөнгө нь 209.8 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 109 дүгээр тогтоолоор 182.4 сая төгрөгийн өртөгтэй “Цахим эрүүл мэнд” программыг акталсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 13,320.4 сая төгрөгөөр ,нийт зарлагыг мөн үнийн дүнгээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,320.4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Үүнд:

- Улсын төсвөөс 890.6 сая төгрөг
- Үндсэн үйл ажиллагааны орлогоос 320 сая төгрөг

Эрүүл мэндийн даатгалын сангаас 12,109.7 сая төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 890.6 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, эрүүл мэндийн даатгалын сангаас 10,147.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 327.1 сая төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж нийт 11,364.8 сая төгрөгийн санхүүжилт авч 1,955.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу авч, урсгал үйл ажиллагаанд 11,359.9 сая төгрөгийг зарцуулж, 4.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчит бус байгууллагаас авсан хандив, туламжаар 8.4 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 539.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 88.2 сая, төвлөрүүлж өнгөрсөн оны үлдэгдлээ эргүүлэн авсан 25.9 сая төгрөг нийт 672.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна. .

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 28.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 5.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 16.3 сая төгрөг, норматив зардалд 6.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 8.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.0 сая төгрөг, түр барилга байгууламж 47.2 сая, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 538.1 сая төгрөг нийт 659.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

- Корона вирус -2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Ковидын тархалттай холбогдсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 2394 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 8633 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 4,239.7 төгрөг нэхэмжилснээс 3,102.6 сая

төгрөгийн санхүүжилт авч 1,137.1 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Авлагыг баталгаажуулсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.

2021 оны төсвийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд үлдээж баталгаажуулсан байна. Энэ байгууллагын харилцах дансанд 17.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

“Жишиг хэмжээ журам батлах тухай” Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны 04 сарын 6 -ны өдрийн 15/А/67 тоот хамтарсан тушаал, урамшууллын хэмжээг тогтоох тухай Нэгдсэн эмнэлгийн захирлын 2021 оны 7 сарын- 1-ний өдрийн Б/294 тоот тушаал, 2021 оны 10 сарын 6-ны өдрийн А/55 тоот тушаалаар ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалд сар бүр 300,000-330,000 төгрөг олгож байсан байна. ТУЗ-ийн гишүүн нийт 9 хүнд 2021 оны 5 сарын 1-с 12 сарын 31-ийг хүртэлх хугацаанд олгосон нийт 23.0 сая цалин урамшуулалд НДШ-ийг тооцож төлөөгүй байсан зөрчил илэрлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд нийт 966.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаас ил тод байршуулахаас 0.4 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.8, 6.8.1, заалтын хүрээнд “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай

- “Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.

### 3.9.3 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж мөрдөх, эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийг данснаас хасах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх тухай 3 зөвлөмж өгсөн байна. Өмнөх аудитын өгсөн 3 зөвлөмжөөс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлах бодох бүртгэлийн хууль тогтоомж стандарт, дүрэм журам зааварт нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж дуусаагүй байна. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

### 3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлах бодох бүртгэлийн хууль тогтоомж стандарт, дүрэм журам зааварт нийцүүлэн НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулсан эсэхийг үзэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.8 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 2.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 5.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны эцсийн ажлын үр дүнгээр олгосон 1 удаагийн тэтгэмж урамшуулал 2.2 сая төгрөгөөс суутгах тооцож төлөх хувь хүний орлогын албан татварыг тайланд тусгаагүй байсныг залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүдэд 2021 оны 5 сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд олгосон нийт 23.0 сая төгрөгийн урамшуулалд даатгуулагчаас суутган төлөх 2.7 сая төгрөг, ажил олгогчийн төлөх 2.9 сая төгрөг, нийт 5.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж төлөөгүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1/ -д “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, 16.1 -д “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Нийгмийн даатгалын тухай хуулийн 16.1, 17-р зүйл, 32.1 заалтын дагуу Нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн гишүүдэд 2021 онд олгосон нийт 23.0 сая төгрөгийн цалин урамшуулалд ногдох нийгмийн даатгалын шимтгэл 5.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж барагдуулах төлбөрийн акт хүргүүлж байна.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

### 1.1 Илрүүлэлт:

Өмнөх аудитын өгсөн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж мөрдөх тухай зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9, 18.2, 20.2.2 заалтын дагуу “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулж мөрдөх.

**2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт**

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд нийт 966.3 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас өр, авлага үүсгэсэн тухай 0.4 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2021 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 0.4 сая төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.8, 6.8.1, заалтын хүрээнд “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгдсэн эмнэлэг	2	7.8	1	2.2	1	5.6				